



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 4/54

Модот

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалт, лабораторийн шинжилгээ, зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, 6.5, 6.6 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын ажлыг 2026 оны 03 дугаар сарын 25-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ийг хүртэлх хугацаанд, лабораторийн тандах шинжилгээний ажлыг өвчний гаралт, тархвар зүйн судалгааг үндэслэн товлосон хугацаанд зохион байгуулсугай.

2.Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг графикт хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн захирал, малын эмч нарт, товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгах, бүрэн хамруулах, тарилгын хашааг барих зэрэг ажлыг малчдаар бэлтгүүлэх ажлыг Багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Шаардагдах эм бэлдмэл, оношлуур хэрэгслийг татан авч мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хуваарилах, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, нэгдсэн тайлан дүн мэдээг Мал эмнэлгийн газарт хүргэж ажиллах, мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийсэн малчин, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (П.Ганчимэг) -т үүрэг болгосугай

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ



